



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/338

Хэрлэн сум

Гамшгаас урьдчилан сэргийлэх арга  
хэмжээнд зориулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, аймгийн Онцгой комиссын 05 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг хангуулах үйл ажиллагаанд шаардагдах 11,017,000 (арван нэгэн сая арван долоон мянган) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны  
06 дугаар сарын 29-ны  
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Байгууллагын нэр	Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн нэр	Үнэ
1	Аймгийн онцгой комисс	Дизель генератор чиргүүл	10.17.000
		Хөдөлгөөнт удирдлагын байрны лед дэлгэц	1.000.000
Нийт			11.017.000